



“ АТАР-ӨРГӨӨ ” ХУВЬЦААТ КОМПАНИ
17060. Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг III хороо
Гудамж-Чингисийн өргөн чөлөө
Утас, Факс: 976-11-342130, 976-11-342132
И-майл: mail@atarurguu.mn
Вэб-сайт: www.atarurguu.mn

2025.03.25 № 46

танай -ны № -т

ҮНЭТ ЦААСНЫ БРОКЕР,
ДИЛЕРИЙН КОМПАНИУДАД

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын баримт
бичиг хүргүүлэх тухай

“Атар-Өргөө” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн хурлаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 08:30 цагаас компанийн байр (Нийслэлийн Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-20)-нд хуралдуулахаар шийдвэрлэж, энэ тухай хувьцаа эзэмшигчид хүргэх зар мэдээллийг Өдрийн сонин, Зууны мэдээ сонин, UBS телевиз, компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар зарлан мэдээлсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх” журмын 3.10 дахь заалтын дагуу ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл зэрэг хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийг нэгтгэн цахим болон биечилсэн хэлбэрээр хүргүүлж байна.

Хувьцаа эзэмшигчдэд хүргэх баримт бичгийг танай компаниар үйлчлүүлдэг “Атар-Өргөө” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд танилцуулж өгөхийг хүсье.

Хувьцаа эзэмшигчдэд хүргэх танилцуулга, саналын хуудсыг хавсаргав.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ж.САЙНБИЛЭГ

“АТАР ӨРГӨӨ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ХҮРГЭХ ТАНИЛЦУУЛГА

“Атар өргөө” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 08:30 цагт компанийн байр (Нийслэлийн Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-20)-нд хуралдуулахаар шийдвэрлэж дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд:

- Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- Компанийн 2024 оны жилийн санхүүгийн тайланд ээлжит аудит хийсэн аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
- Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулалын хэмжээг тогтоож, дотоод ажлын зардлын төсвийг батлах;

Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээллийг 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн Зууны мэдээ, Өглөөний сонин, UBS телевиз, Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар тус тус мэдээлсэн.

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийн төсөл

“Атар өргөө” ХК, түүний алба, нэгж, Гүйцэтгэх удирдлага 2024 онд 10,1 тербум төгрөгийн борлуулалт хийж 104,1 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Компани, түүний гүйцэтгэх удирдлага төлөвлөгөө, төлөвлөлтгэйгөөр үйл ажиллагаагаа зохион байгуулж, эдийн засгийн амаргүй орчинд зах зээлийнхээ эзлэх байр сууриа хадгалж авч үлдэх, шинэ бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг татах зэрэг үйлдвэрлэлийн стандартыг баримтлан ажилласан байна.

Төлөөлөн удирдах зөвлөл Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Гүйцэтгэх удирдлагаас гаргасан тайлантай танилцаад дараах дүгнэлт гаргаж байна. Үүнд:

“Атар өргөө” ХК нь:

1. Дотоод хяналт шалгалтыг сайжруулах замаар үйлдвэрлэлийн өгөөж, ажил үүргийн хуваарийг нэмэгдүүлсэн
2. Өмч хөрөнгө, бэлэн болон бэлэн бус мөнгөн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтайгаар үйлдвэрлэлд зарцуулахад анхаарч ажилласан.
3. Эрсдэлд суурилсан бодлогын бичиг баримтыг шинэчлэн батласан.
4. Өөрийн хөрөнгөөр шинэ тоног төхөөрөмжүүдээр үйл ажиллагаагаа сайжруусан, хөрөнгө оруулалтыг зээлээр биш өөрийн хөрөнгөөр шийдвэрлэж, үйлдвэрлэлд шаардлагатай засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэсэн байна.
5. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг сахин хамгаалж зөрчилгүй ажиллаж чадсан.
6. Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж ажилласан.

7. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэлийн өгөөжийг нэмэгдүүлж ажилласан байна.

Энэ талаар Гүйцэтгэх захирлаас Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж байгаа үйл ажиллагааны тайланд тусгагдсан бөгөөд үйл ажиллагааны үр дүнг тайландаа бүрэн зөв тусгасан байна хэмээн үзэж, гүйцэтгэх захирал чиг үүргээ хангалттай биелүүлсэн гэж дүгнэж байна.

Мөн түүнчлэн жил бүрийн бизнесийн төлөвлөгөө бүрэн биелэхгүй байгаад дүгнэлт хийж бизнес төлөвлөгөөг үндэслэл сайтай биелэгдэхүйц байдлаар боловсруулах шаардлагатай гэж үзэв.

“Атар өргөө” ХК-ийн 2024 оны үйл ажиллагаа, борлуулалтын орлого, үйлдвэрлэлийн зардлын харьцааг харгалзан үзэж ногдол ашиг хувиарлахгүй байхаар шийдвэрлэсэн байна.

Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгөх дүгнэлтийн төслийг батлах саналыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж байна.

Аудитын дүгнэлтийн тухай

“Атар-Өргөө” ХК, Мүүрь аудит ХХК-ийн хооронд 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан МА-2024-СТА 44 дугаартай “Санхүүгийн тайланд аудит хийх ажлын гэрээ”-ний дагуу аудитын ажил графикт хугацаагаар хийгдэж байгаа бөгөөд аудитын дүгнэлтийг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр захиалагчид ирүүлэх хугацаатай. Иймд аудитын дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах болно.

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

“Атар-Өргөө” ХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 104,1 сая төгрөгийн /татвар ноогдоогүй дүнгээр/ ашигтай ажилсан. Гэвч түүхий эдийн материал татах, тээврийн зардлын болон ус, дулаан, цахилгаан, зэрэг урсгал зардлуудын үнийн өсөлт, үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдийн шинэчилэлт хийх хэрэгцээ шаардлага зэрэг нь санхүүгийн зохистой харилцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хувиарлахгүй болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуульд зааснаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хийх өдрөөр дуусгавар болох, одоо мөрдөж байгаа Компанийн дүрмээр төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдийн тоог ес, үүнээс хараат бус гишүүний тоог гурав байхаар тогтоосон.

Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хороо дор дурьдсан хүмүүсийг Төлөөлөн удирдах зөвлөлд сонгогдох нэрийн жагсаалтад тус тус бүртгэн авч, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэрийг нь дэвшүүлсэн тухай шийдвэр гаргасан болно.

Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийн товч танилцуулга

Бэрэнбаралын Мөнхдалай

Б.Мөнхдалай 1962 онд Архангай аймгийн Өндөр-Улаан суманд төрсөн. Эхнэр хүүхдийн хамт амьдардаг. Дээд боловсролтой. ЗХУ-ын Эрхүү хотын хэлний бэлтгэлд суралцан Харьков хотын Политехникийн дээд сургуулийг 1986 онд холбооны электроник, уул уурхайн цахилгаан механик инженерийн мэргэжлээр төгссөн. 1986-1991 онд “Багануурын Нүүрсний уурхай”-д инженерээр, 1992-1997 онд “Бэрэн” ХХК-д инженерээр, 1997-2001 оныг хүртэл “Бэрэн” ХХК дэд захирлаар, 2006-2016 он хүртэл “Бэрэн майнинг” ХК-ийн Ерөнхий захирал, 1997 оноос одоог хүртэл “Атар өргөө” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр ажиллаж байгаа бөгөөд 2012 оны 3 дугаар сараас тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байна.

Бэрэнбаралын Ганбат

Б.Ганбат нь 1960 онд Архангай аймгийн Өндөр-Улаан суманд төрсөн. Эрэгтэй. Ам бүл 4. Эхнэр хүүхдийн хамт амьдардаг. Дээд боловсролтой. 1977-1981 онд Хялгантын ойн техникумыг Ойн техникч, механикчийн мэргэжлээр, 1984-1988 онд ПТДС-ийг авто инженерийн мэргэжлээр тус тус суралцаж төгссөн. 1983-1986 онд УААЯ-ны авто баазын жолоочоор, 1990-2000 онд Бэрэн ХХК-д менежер, орлогч захирлаар, 2002 оноос одоог хүртэл “Нэхээсгүй эдлэл” ХК-ийн ерөнхий захирлаар ажиллаж байна. 2000 оноос “Атар Өргөө” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Жамцын Сайнбилэг

Ж.Сайнбилэг нь 1796 онд Хөвсгөл аймагт төрсөн. Эмэгтэй. Нөхөр хүүхдүүдийн хамт амьдардаг. Дээд боловсролтой. Орхон дээд сургуулийг 1998 онд Англи хэлний орчуулагч мэргэжлээр, 2003 онд Санхүү эдийн засгийн их сургуулийг Зээлийн эдийн засагч мэргэжлээр тус тус төгссөн. Бизнесийн удирдлагын бакалавр цолтой. 2003-2005 онд “Бэрэн Констракшн” ХХК-ийн дэд захирал, 2005-2016 онд “Бэрэн майнинг” ХК-ийн дэд захирал, 2015 оны 01 дүгээр сараас “Атар өргөө” хувьцаат компанийн ерөнхий захирлын орлогч захирал, 2016 оны 04 дүгээр сараас Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байна. 2016 оноос “Атар өргөө” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Ганзоригийн Баттулга

Г.Баттулга нь 1986 онд Улаанбаатар хотод төрсөн. Эрэгтэй. Эхнэр 2 хүүхдийн хамт амьдардаг. Дээд боловсролтой, Раффлес олон улсын коллежийг 2012 онд ерөнхий менежментээр төгссөн. Бизнесийн удирдлага бакалавр зэрэгтэй. 2004-2005 онд “ГТБ-Булган гурил тэжээл” ХК-д менежер, 2005-2007 онд гүйцэтгэх захирлаар, 2013-2015 онд “Бэрэн металл” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар, 2012 оноос хойш “Атар өргөө” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Цолмонгийн Галтаа

Ц.Галтаа нь 1984 онд Улаанбаатар хотод төрсөн. Эрэгтэй. Эхнэр 2 хүүхдийн хамт амьдардаг. Ерөнхий боловсролын 76-р сургуулийг 1992-2001 онд, ОХУ-ын Волгоград хот дахь Дотоод хэргийн яамны академийг Эрх зүйч мэргэжлээр, 2004-2009 онд төгссөн. Сингапур улсын Стенсфийл коллежийн хуулийн ангийг 2010-2011 онд, МУИС –ийн Хуулийн сургуульд 2012-2019 онд магистрийн зэрэг тус тус хамгаалсан. Англи, Орос хэлтэй. Монголын өмгөөлөгчдийн холбооны гадаад харилцааны мэргэжилтнээр, 2019 оноос өмгөөлөгчөөр ажиллаж байна.

Дүгэрийн Даваадорж

Д.Даваадорж нь 1967 онд Өвөрхангай аймгийн Хархорин суманд төрсөн. Эрэгтэй. Эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг. Дээд боловсролтой. 1992 онд АУИС-ийг “Хүний их эмч” мэргэжлээр төгссөн. Польш улсын Лоз хотын Анагаах ухааны их сургуулийг 2004 онд төгссөн. Доктор профессор цолтой. 1992-2013 он ЭМСУИС-ийн ахлах багш, 2013 оноос Анагаахын үндэсний их сургуулийн дэд захирал, 2007 оноос Улаанбаатар Сонгодо эмнэлэгийн зөвлөх эмч, Улсын хавдар судлалын үндэсний төвийн зөвлөх эмч, элэг шилжүүлэн суулгах үндэсний багын гишүүнээр тус тус ажилласан байна. Мөн 2006 оноос эрүүл мэндийн яамны элэгний эмгэгийн ерөнхий мэргэжилтэн, 2008-2014 онд Монголын гастро энтралогийн холбооны дэд ерөнхийлөгч, 2014 оноос ерөнхийлөгчөөр ажиллаж байна. 2015 оноос “Атар өргөө” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Мөнхдалайн Мөнхтэнгис

М.Мөнхтэнгис нь 1995 онд Улаанбаатар хотод төрсөн. Эрэгтэй. Ам бүл 5. Эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг. 2002-2012 онд Сант бүрэн дунд сургууль, 2013-2017 онд Австрали улс дахь Күйнсландийн их сургуулийг тус тус дүүргэсэн бөгөөд одоогоор хувираа бизнес эрхэлдэг.

Сүхбаатарын Бямбахорлоо

С.Бямбахорлоо нь 1982 онд Өвөрхангай аймгийн Хужирт суманд төрсөн. Эрэгтэй. Эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг. Дээд боловсролтой. Мандах бүртгэл дээд сургуулийг 2003 онд Нягтлан бодогч мэргэжлээр төгссөн. 2005 онд МУИС-ийг Бизнесийн удирдлагын магистр, 2015 онд СЭЗДС-ийг Бизнесийн удирдлагын Доктор зэргийг тус тус хамгаалсан. 2006 онд Мэргэшсэн

нягтлан бодогч, 2010 онд МУ-ын Аудитор, 2011 онд татварын мэргэшсэн зөвлөх зэргийг тус тус хүртсэн.

2003-2003 онд Тээвэр хөгжлийн банкинд Нягтлан бодогч, 2005 оноос өнөөг хүртэл СЭЗДС-ийн ахлах багшаар ажиллаж байна. 2016 оноос “Атар Өргөө” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Ганзоригийн Энхболд

Г.Энхболд нь 1984 онд Улаанбаатар хотод төрсөн. Ам бүл 4, эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг. Нийслэлийн ерөнхий боловсролын 11 дүгээр сургуулийг төгссөн. Сити дээд сургуулийг маркетингийн менежер мэргэжлээр тус тус төгссөн. Одоогоор “Бэрэн Майнинг” ХК-д Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Лхагвын Ганпүрэв

Л.Ганпүрэв нь 1967 онд Ховд аймагийн Мөст суманд төрсөн. Эрэгтэй. Эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг. Ховд аймгийн Мөст сумын 2-р сургууль, УБ хот Барилгын техникумыг Барилгын инженер мэргэжлээр дараа нь Политехникийн дунд сургуулийг Барилгын инженер Япон улс Окайда хот Хөдөө аж ахуйн их сургууль, Отгонтэнгэр их сургуулийг Эрх зүйч мэргэжлээр төгссөн. ЗХУ-д Иркутск хотын Зургийн институтанд туршлага судалсан. Улсын барилгын зургийн төв институтад Зургийн техникч, Дархан техникийн их сургуульд багш, Дархан Уул аймагт “Мах экспо” ХК-ийн дэд захирлаар, “Тайж трейд” ХХК-ийн ерөнхий захирлаар ажиллаж байна.

Пүрэвийн Болормаа

П.Болормаа нь 1979 он Улаанбаатар хотод төрсөн. Эмэгтэй. Нөхөр хүүхдүүдийн хамт амьдардаг. Эрдэнэт хотын 1-р сургууль ШУТИС-ийн КТМС-ийг Санхүүгийн удирдлага мэргэжлээр дүүргэсэн. 2004-2005 онд MCS үйлчилгээний алба, 2015-с ICMA олон улсын боловсролын төв ХХК-д захирлаар ажиллаж байна.

Ганжууржавын Оюун

Г.Оюун нь 1951 онд Улаанбаатар хотод төрсөн. Хүүхдүүдийн хамт амьдардаг. Улаанбаатар хотын 2-р сургууль, Худалдааны техникумыг Нягтлан бодогчоор, ЗХУ-ын Москва хотод ХАҮТДС-ийг Хүнсний үйлдвэрийн инженер технилоич мэргэжлээр тус тус дүүргэсэн. Улаанбаатар хотод талхны үйлдвэрт ажилтан, мастер, цехийн дарга зэрэг албан тушаал эрхлэж байсан. ХХҮЭШЗТИ-д эрдэм шинжилгээний ажилтан, Секторийн эрхлэгч, инженер ХХЭШҮ-ийн Само институт баталгаажилтын байцаагч гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Тогоогийн Жигмэддагва

Т.Жигмэддагва нь 1962 онд Улаанбаатар хотод төрсөн. Эрэгтэй. Эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг. Улаанбаатар хотын 2-р сургууль, Худалдааны техникумыг 1982 онд Нягтлан бодогч мэргэжлээр, 1985-1991 онд Оросын холбооны улсын Эрхүү хотод УААДС-ийг АА-ын шинжилгээний эдийн засагч мэргэжлээр тус тус дүүргэсэн. 2007 оноос DCF-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байна.

Эдгээр нэр дэвшигчдээс Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн болон хараат бус гишүүдийг сонгох бөгөөд тарааж өгсөн саналын хуудсаар тус тусад нь кумулятив аргаар саналаа өгнө үү.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшуулалын хэмжээг тогтоож, зардал батлах тухай

Компанийн тухай хууль, компанийн дүрмээр Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдээгүйн цалин урамшуулалын хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэж байхаар тогтоосон билээ. Хууль, дүрмийн энхзүү заалтыг үндэслэн тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшуулалын хэмжээ дотоод ажлын жилийн зардлын төсвийг батлуулахаар оруулж байна. Тус компанийн дүрэмд Төлөөлөн удирдах зөвлөл нь есөн гишүүнтэй, нарийн бичгийн даргатай байхаар тогтоосон бөгөөд тэдний сарын цалинг дор дурдсан хэмжээгээр тогтоох санал оруулж байна.

Албан тушаал	Тоо	Сарын цалингийн хэмжээ (төгрөгөөр)	
		нэгжийн	бүгд
Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүн	9	660,000.00	71.280,000.00
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн хурлын ирцийн урамшуулал	4	100,000.00	3,600,000.00
Нарийн бичгийн дарга	1	1,800,000.00	21,600,000.00

Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод ажлын зардлыг цалин урамшуулалыг оролцуулахгүйгээр 5,225,000.00 төгрөгөөр батлуулахаар оруулж байна.

КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Компанийн хувьцаа эзэмшигч Та энэ удаагийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй танилцаж, хавсаргаж хүргүүлсэн саналын хуудсаар саналаа өгөхийг хүсэе.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөр, хуралд биеэр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүлээж авах сүүлийн хугацааг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 17:00 цагаар тус тус тогтоосон болно.

Ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төслийн талаар лавлах, дэлгэрэнгүй мэдээлэл авах бол 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс мөн оны 04 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл хугацаанд компанийн байр (Нийслэлийн Хан-Уул дүүргийн 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө-20)-нд мэдээлэл авах боломжтой болно.

Хувьцаа эзэмшигч Таныг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 08:30 цагаас компанийн байр (Нийслэлийн Хан-Уул дүүргийн 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө-20)-нд хуралдуулахаар товлосон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцохыг урьж байна.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл, санал авах хуудсыг хавсаргав.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдтэй
холбогдох мэдээлэл авах утас: 9933-3458-Б.Ханхүслэн
цахим хаяг: batboldh@gmail.com

ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСЛҮҮД

Тооллогын комиссын тогтоолыг батлах тухай

“Атар өргөө” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ НЬ:

“Атар өргөө” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын “Хурлын ирц, хурлыг хүчин төгөлдөр тооцох тухай” оны сарын өдрийн, “Саналын хуудсаар санал өгсөн саналын эрхийг тоолсон тооллогын комиссын дүнгийн тухай” оны сарын өдрийн тоот тогтоолыг тус тус баталсугай.

Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай

“Атар Өргөө” ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтэнд хувьцаа эзэмшигчдээс өгсөн санал, Тооллогын комиссын ... оны сарын өдрийн тоот тогтоолыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч, баталсугай.
2. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтэд дэвшүүлсэн саналыг хэрэгжүүлж ажиллахыг шинээр сонгогдох Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

Аудитын дүгнэтийг зөвшөөрөх тухай

“Атар өргөө” ХК-ийн 2024 оны жилийн санхүүгийн тайланд ээлжит аудит хийсэн “Мүүрь аудит” ХХК-ийн аудитын дүгнэлтийн талаар хувьцаа эзэмшигчдээс өгсөн санал тооллогын комиссын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн дугаар тогтоолыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ НЬ:

“Атар өргөө” ХК-ийн 2024 оны жилийн санхүүгийн тайланд аудит хийсэн “Мүүрь аудит” ХХК-ийн аудитын дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг зөвшөөрөх тухай

Компанийн хувьцаа эзэмшигчдэд “Ногдол ашиг хувиарлахгүй тухай” Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр (2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 25/01) –г хувьцаа эзэмшигчдээс өгсөн санал, тооллогын комиссын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн дугаар тогтоолыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ НЬ:

“Ногдол ашиг хувиарлахгүй тухай” Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр (2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 25/01)-ийг зөвшөөрсүгэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсоныг батлаж, бүрэн эрхийг зөвшөөрөх тухай

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, компанийн дүрмийн “Долоо”-ийн 7.22 дахь заалт, хувьцаа эзэмшигчдээс кумулятив аргаар өгсөн санал, тооллогын комиссын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

Дор дурдсан хүмүүсийг “Атар Өргөө” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн ба хараат бус гишүүнээр сонгогдсоныг батлаж, бүрэн эрхийг зөвшөөрсүгэй. Үүнд:

Ердийн гишүүнээр

Хараат бус гишүүнээр

Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин, урамшуулал, дотоод ажлын зардлын төсвийг батлах тухай

“Атар өргөө” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалингийн хэмжээ болон дотоод ажлын зардлын төсвийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс өгсөн санал, тооллогын комиссын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшуулал, дотоод ажлын зардлын төсөв” –ийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.